



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/16

Мандалговь

“Шилдэг номын тэмдэглэл” цахим уралдаан  
зохион байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.5 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Залуучуудын хөгжлийн төвөөс “С.Буяннэмэх”-ийн нэрэмжит аймгийн Төв номын сантай хамтарсан “Цахим номын сан” хөтөлбрийн хүрээнд зохион байгуулагдах “Шилдэг номын тэмдэглэл” шалгаруулах цахим уралдааныг 2021 оны 03 дугаар сарын 1-ний өдрөөс 04 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, төсвийн 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Шилдэг номын тэмдэглэл” шалгаруулах уралдаанд зарцуулагдах 200,000 (Хоёр зуун дөчин мянган) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С. Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг ханган, үр дүнтэй зохион байгуулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан (Т.Насандэлгэр)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Насандэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

431193033

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2021 оны 2 дугаар сарын 22 ны өдрийн  
116 дугаа тушаалын 3 дүгээр хавсралт



“ШИЛДЭГ НОМЫН ТЭМДЭГЛЭЛ” ЦАХИМ  
УРАЛДААНЫ ТӨСӨВ

| №    | Материалын нэр | Нэг бүрийн<br>үнэ | Тоо | Хэмжих<br>нэгж | Нийт үнэ |
|------|----------------|-------------------|-----|----------------|----------|
| 1    | Ялагч-1        | 40,000            | 1   | Ш              | 40,000   |
| 2    | Ялагч-2        | 40,000            | 1   | Ш              | 40,000   |
| 3    | Ялагч-3        | 40,000            | 1   | Ш              | 40,000   |
| 4    | Ялагч-4        | 40,000            | 1   | Ш              | 40,000   |
| 5    | Өргөмжлөл      | 10,000            | 4   | Ш              | 40,000   |
| Нийт |                | 200,000           |     |                |          |